




БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ:  
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
(Гарын усгэг)  
Ш.ИДЭРБАЯСГАЛАН



ЗӨВШӨӨРСӨН

САНХҮҮ ТӨВИЙН САНГИЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

(Гарын усгэг)  
Г.БАЗАР



ГҮЙЦЭТГЭГЧ:

"ЭМ ЭМ ИНЖЕНЕРИНГ" ХХК-  
ИЙН ЗАХИРАЛ  
XXK

(Гарын усгэг)  
Д.МИНЖБАДГАР

ХАНХ СУМЫН "СОЁЛЫН ТӨВ"-ИЙН БАРИЛГА (250 ХҮНИЙ ЧАДАЛТАЙ)  
БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨВ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ  
Дугаар № ХӨАОНӨГ/202201157-100

Хөвсгөл аймаг

Нэг талаас Хөвсгөл аймгийн Засаг дарга Ш.Идэрбаясгалан (цаашид "захиалагч" тэх), нөгөө талаас "Эм Эм Инженеринг" ХХК-ийн захирал Д.Минжбадгар /Улаанбаатар хот, Хан -Уул дүүрэг 18-р хороо Удирдлагын академийн гудамж Академи-2 хотрон 36/2 101 тоот (цаашид "зөвлөх" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2022 оны 10 сарын 03-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав. Үүнд:

|                     |   |
|---------------------|---|
| <b>1. Үйлчилгээ</b> | <p>1. Зөвлөх нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болох</p> <p>1.1. Хавсралт №1-д тодорхойлсон Ханх сумын "Соёлын төвийн" барилга (250 хүний хүчин чадалтай) барилгын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний" зөвлөх үйлчилгээ үзүүлэх үе шатны <b>хуваарь</b>-т заасан ажил үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй.</p> <p>1.2. Зөвлөх нь үйлчилгээг үзүүлэхдээ Хавсралт №2-т тодорхойлсон "Ажлын хөтөлбөр аргачлал"-т заасан маягтаар түүнд товлосон хугацаанд тайлангууд гаргаж захиалагчид ирүүлнэ.</p> <p>1.3. Зөвлөх нь Хавсралт №3-т тодорхойлсон ажиллах хүчиний ажлын <b>хуваарьт</b>-д заасан мэргэжилтнүүдийг ажиллуулах үүрэгтэй.</p> <p>1.4. Энэхүү гэрээ нь хавсралт №4-т заасан гэрээний ерөнхий нөхцөл, болон хавсралт №5-д заасан тусгай нөхцөлийн хамт хүчин төгөлдөр байх бөгөөд захиалагч болон зөвлөх нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан үүргийг заавал хэрэгжүүлж мөрднө.</p>   |
| <b>2. Хугацаа</b>   | <p>2.1. Зөвлөх нь үйлчилгээг <b>2022 оны 10 сарын 03-ний өдрөөс эхэлж 2022 оны 12 сарын 01-ний өдөр дуусгана.</b></p>   |
| <b>3. Төлбөр</b>    | <p>3.1. <u>Санхүүжилтийн эх үүсвэр:</u> Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн зураг төслийн сангийн хөрөнгөөр санхүүжих</p> <p>3.2. <u>Төлбөрийн дээд хэмжээ.</u> Захиалагч нь зөвлөхдээ Хавсралт 1-ийн дагуу үзүүлсэн үйлчилгээний төлбөрт төлөх дээд хэмжээ нь <b>33,105,079 (Гучин гурван сая нэг зуун таван мянга далан есөн )</b> төгрөг болно. Энэ дунд зөвлөхийн бүх зардал, ашиг, мөн түүнчлэн зөвлөхөд ногдож болох аливаа татвар, хураамж орсон болно.</p> <p>3.3. <u>Төлбөрийн хуваарь.</u><br/>Төлбөрийг доорх хуваарийн дагуу хийн:<sup>1</sup> Гэрээний үнийн дүнгийн 0 хувьтай тэнцэх дүнг дунд хугацааны тайлан, мэргэжлийн байгууллагын тайлан төсөл, бэлтгэл судалгаа, хээрийн тодруулга, судалгаа, ажлын гүйцэтгэл ирүүлсний дараа төлж болно. / 2022 онд санхүүжих дүн /</p> <p>(б) Гэрээний үнийн дүнгийн 100 хувьтай тэнцэх дүнг баталгаажсан эцсийн тайлан, судалгааны тайлан, ажлын гүйцэтгэл, захиалагчийн төлөөлөгчийн тайлан хүлээн авсан тухай акт, гэрээ дүгнэсэн акт холбогдох бусад баримт бичгийг ирүүлсний дараа төлж болно.</p> |

<sup>1</sup> Хавсралт 3-т тодорхойсон үйлчилгээний үр дүнг харгалzan өөрчлөнө.

Захиалагчийг төлөөлж.....

Гүйцэтгэгчийг төлөөлж.....

|                              |   |
|------------------------------|---|
|                              | <p>Эсхүл баталгаажсан эцсийн тайлан, судалгааны тайлан, ажлын гүйцэтгэл, захиалагчийн төлөөлөгчийн тайлан хүлээн авсан тухай акт, гэрээ дүгнэсэн акт холбогдох бусад баримт бичгийг захиалагчид ирүүлсний дараа захиалагчаас зөвлөхөд олгох гэрээний төлбөрийг 100 хувь олгож болно. / 2022 онд санхүүжинэ /</p> <p>(в) Урьдчилгаа төлбөр хийгдэхгүй. <b>Нийт төлж болох урьдчилгааны хэмжээ: 0 төгрөг.</b></p> <p><b>3.4. Төлбөрийн нөхцөл.</b></p> <p>Төлбөрийг 4 дүгээр зүйлд заасан төлбөрийн нэхэмжлэхийн хувь, гэрээ дүгнэсэн акт, зураг төсөл, өргтийн төсөв, гэрээнд заасан бусад баримт бичгийг хүлээн авсан акт, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан журманд заасан баримт бичгийг төслийн зохицуулагчид ирүүлснээс хойш 30 хоногийн дотор төгрөг-өөр хийнэ.</p> <p>Зөвлөх “Эм Эм инженеринг” ХХК-ийн регистрийн дугаар: 2715961</p>                       |
| <b>4. Төслийн удирдлага</b>  | <p><b>Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл:</b></p> <p>Эцэг/эх-ийн нэр: Хадбаатар<br/>Нэр: Даваасүрэн<br/>Албан тушаал: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн<br/>Ажлын утас: 80039579<br/>Гар утас: 80039579<br/>Цахим шуудан:<br/>Захиалагчийн төлөөлөгч нь гэрээний дагуу хийгдэх үйл ажиллагааг зохицуулах, төлбөрийн нэхэмжлэх, тайлан болон бусад бичиг баримт, эд зүйлсийг хүлээн авч батлах үүргийг хүлээнэ.<br/><b>Зөвлөхийн төлөөлөгчийн мэдээлэл:</b><br/>Эцэг/эх-ийн нэр: Д<br/>Нэр: Минжбадгар<br/>Албан тушаал: Захирал<br/>Ажлын утас: 77273578<br/>Гар утас: 99085692<br/>Цахим шуудан: mmengineering2002@gmail.com<br/>энэхүү зохицуулагч нь гэрээний дагуу хийгдэх үйл ажиллагааг зохицуулах, төлбөрийн нэхэмжлэх, тайлан болон бусад бичиг баримт, эд зүйлсийг хүлээн авч батлах үүргийг хүлээнэ.</p> |
|                              | <p><b>4.1. Тайлан:</b> Зөвлөх нь Хавсралт 2-т тодорхойлсон “Зөвлөхийн тайлан гаргах хуваарь”-т заасан тайланг хуваарийн дагуу ирүүлэх, бөгөөд энэ нь 3 дугаар зүйлийн дагуу төлбөр хийх үндэслэл болно.</p>   |
| <b>5. Гүйцэтгэлийн чанар</b> | <p><b>5.1.</b> Зөвлөх нь үйлчилгээг мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд үнэнч шударгаар үзүүлнэ. Энэхүү гэрээний дагуу зөвлөхийн ажиллуулж буй аливаа ажилтан шаардлага хангаагүй гэж захиалагч үзсэн бол зөвлөх уг ажилтныг нэн даруй солино.</p>   |
| <b>6. Нууцлал</b>            | <p><b>6.1.</b> Зөвлөх нь гэрээний хэрэгжилтийн явцад, мөн түүнийг дуусгавар болсноос хойш хоёр жилийн дотор зөвлөхийн үйлчилгээ болон энэ гэрээтэй холбоотой өмчлөлийн болон нууцлах шаардлагатай мэдээллийг, эсхүл захиалагчийн бизнесийн болон үйл ажиллагааны талаар захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүй задруулах эрхгүй.</p>  |
|                              | <p><b>7.1.</b> Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж зөвлөхийн</p>  |

Захиалагчийг төлөөлж.....

Гүйцэтгэгчийг төлөөлж.....

|   |   |
|---|---|
| 7. Өмчлөл   | боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамж болон бусад материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэнэ. Зөвлөх нь эдгээр бичиг баримт болон программ хангамжийн <sup>2</sup> хувийг авч болно.  |
| 8. Зөвлөх зарим нэг үйл ажиллагаанд оролцохгүй байх | 8.1. Зөвлөх, түүний нэгдмэл сонирхолтой аливаа этгээд нь энэ гэрээний хугацаанд болон гэрээ дуусгавар болсноос хойш энэ үйлчилгээнээс үүсэлтэй, эсхүл түүнтэй нягт холбоотой аливаа төслийн бараа, ажил, үйлчилгээ (энэ үйлчилгээ болон түүний үргэлжлэлээс бусад)-ний гүйцэтгэгчээр ажиллах эрхгүй болохыг зөвлөх хүлээн зөвшөөрч байна. |
| 9. Даатгал  | 9.1. Зөвлөх нь шаардлагатай бүх даатгалыг өөрийн зардлаар хариуцна.   |
| 10. Эрх шилжүүлэлт                                  | 10.1. Зөвлөх нь захиалагчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ бусад этгээдэд шилжүүлэх, эсхүл түүний аливаа хэсгийг туслан гүйцэтгүүлэх гэрээ байгуулах эрхгүй.  |
| 11. Гэрээнд мөрдөх хууль ба хэл,                    | 11.1. Энэ гэрээнд Монгол Улсын хуулийг дагаж мөрдөх ба гэрээний хэл нь <b>Монгол</b> <sup>3</sup> хэл байна.  |
| 12. Маргааныг шийдвэрлэх <sup>4</sup>               | 12.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргаж асуудлыг шийдвэрлүүлнэ.  |
| 13.   | 13.1. Гэрээнд заасан нэр бүхий Ханх сумын “Соёлын төвийн” барилга (250 хүний хучин чадалтай) барилгын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхээр захиалагчийн баталсан ажлын даалгавар, гэрээний хавсралтууд нь энэ гэрээний салшгүй хэсэг байна.  |

### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ  
ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

.....Б.ОЮУНТУЯА

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

.....Б.ДОЛЖИНСОРОГДОГ

АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР  
.....Х.ДАВААСҮРЭН

<sup>2</sup> Хэрэв эдгээр бичиг баримт болон программ хангамжийг цашид хэрэглэхийг хязгаарлах шаардлагатай бол 7 дугаар зүйлийн эцэст нэмж оруулна.

<sup>3</sup> Зөвлөхийг сонгох ажиллагаанд гадаадын компаниуд орж байгаа бол хэрэглэх хэл нь англи, франц, эсхүл испани гэх мэт гадаад хэл байж болно.

<sup>4</sup> Гадаадын зөвлөхтэй гэрээ байгуулж байгаа тохиолдолд 12 дугаар зүйлийг “Энэ гэрээнээс үүдсэн болон энэ гэрээтэй холбогдсон, эсхүл түүнийг зөрчсөн, түүнийг дуусгавар болгосон юм уу хүчингүй болсонтой холбогдсон аливаа маргаан, зөрчилдөөн, нэхэмжлэхийг хучин төгөлдөр үйлчилж буй UNCTRAL-ын арбитрын журмын дагуу шийдвэрлэн.” гэсэн заалтаар сольж болно.

### ЗӨВЛӨХИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ЭМ ЭМ ИНЖЕНЕРИНГ” ХХК-ИЙН  
АРХИТЕКТОРИ  
.....ИНЖЕНЕРИНГ  
ХХК

.....Э.СОДМАНДАХ

Утас: 99108632

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул  
дүүрэг 18-р хороо Удирдлагын  
академи-2 хотхон 36/2 101 тоот

Харилцагч банк: Худалдаа

Хөгжлийн банк

Данс: 2611015498

Регистрийн дугаар: 2715961

Захиалагчийг төлөөлж..... Гүйцэтгэгчийг төлөөлж.....

ХӨДӨӨНӨГ/202201157-100  
дугаар гэрээний хавсралт № 1

Гэрээний нэр: Ханх сумын "Соёлын төв"-ийн барилга (250 хүний хүчин чадалтай) барилгын ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх  
Үйлчилгээ нийлүүлэх гэрээ

БТ 16129361 4131053

### АЖЛЫН ҮЕ ШАТНЫ ХУВААРЬ

#### 3.8. АЖЛЫН ХУВААРЬ

##### А. Ажлын талбайд хийх шинжилгээ, судалгаа

| №  | Ажлын үе шат   | Гэрээз байгуулалтадсан эхийн өдөрөөс / Ажлын 5 хоногоор |   |   |   |   |   |
|----|--|---|---|---|---|---|---|
|    |  | 1   | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1  | Гэрээний багтгэл   |   |   |   |   |   |   |
| 2  | Барилгын эсийн багтгаалкуулах                                    |   |   |   |   |   |   |
| 3  | Базар дээр нь хийх судалгаа                                      |   |   |   |   |   |   |
| 4  | Берэний төвлөгөөгээ төннүүцэж тооцоог дахин хийж баталгаажуулах  |   |   |   |   |   |   |
| 5  | Техникийн нехцэл авахад шаардлагатай хүчин чадлыг тооцож бэлтгэх |   |   |   |   |   |   |
| 6  | Хангачыг байгуулалтуудтай эх үүсвэрэрийн талаар тохиолцох        |   |   |   |   |   |   |
| 7  | Трасс зөвшөөрөлийх   |   |   |   |   |   |   |
| 8  | Дэвсээр зурах хийгүйх  |   |   |   |   |   |   |
| 9  | Ижненр геологийн судалгаа  |   |   |   |   |   |   |
| 10 | Барилгын ЕТ, ажлын зураг боловсруулалт                           |   |   |   |   |   |   |
| 11 | Дулааны, цэвэр усны шугамын төлөвлөлийн зураг                    |   |   |   |   |   |   |
| 12 | Гадна дохир дэсны шугамын төлөвлөлийн зураг                      |   |   |   |   |   |   |
| 13 | Гадна цахилгаант, гаднаа гэрэлзүүлийн төлөвлөлийн зураг          |   |   |   |   |   |   |
| 14 | Гадна холбоо хангамжийн төлөвлөлийн зураг                        |   |   |   |   |   |   |
| 15 | Барилгын зураг төслийг нэгтгэж хийнх                             |   |   |   |   |   |   |
| 16 | Дахин шалгах   |   |   |   |   |   |   |
| 17 | Төсөв  |   |   |   |   |   |   |
| 18 | ОбБЕГ-тай зөвшөөрөлийх   |   |   |   |   |   |   |
| 19 | Экспертиза   |   |   |   |   |   |   |
| 20 | Зураг төсөл хүзээгэн өгөх  |   |   |   |   |   |   |

##### В. Ажлыг дуусгаж тайллан өгөх

| 1. Эхийн тайлтан  | Тайлтан | Он сар өдөр                               |
|-------------------|---------|---|
| 2. Явьын тайлтан  |         | Гэрээз байгуулалтадсан хойш ажлын 7 хоног |
| 3. Эцсийн тайлтан |         | Зураг төсөл хүзээгэн өгөх                 |

Таних тэмдэг

Тайлбар

|   |  |  |
|---|--|--|
| Бэлтгэл үе шат                                |  |  |
| Барилгын ажлын зураг                          |  |  |
| Гадна инженерийн шугам сүржээ                 |  |  |
| Холбогдох байгууллагатас зөвшөөрөл авах хасаг |  |  |

Захиалагчийг төлөөлж.....

Гүйцэтгэгчийг төлөөлж.....

ХӨАОНӨГ/202201157-100  
дугаар гэрээний хавсралт № 2

6716129361 4131053

### 3.4. ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

Хөвсгөл аймгийн Ханх суманд баригдах 250 хүний хүчин чадалтай “Соёлын төв”-ы барилгын ажлыг манай байгууллага “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм”-ийн дагуу 1 үе шаттайгаар, “Ажлын зургийн гэрээ” байгуулснаас хойш хуанлийн 30 хоногт боловсруулахаар ажиллана.

Дээрх хоногт магадлалаар оруулах хугацааг тооцсон болно.

“Ажлын зураг, төсөв”-г дараах хөтөлбөрийн дагуу гаргана.

1. Гэрээ байгуулах:
  - “Ажлын зураг, төсөв” боловсруулах гэрээ байгуулах
2. Бэлтгэл ажил:
  - Захиалагч байгууллагаас, барилга байгууламж барих газрын ерөнхий мэдээлэл авах /газрын захирамж, гэрээ, гэрчилгээ, кадастрын хуулбар/
  - Барилга байгууламжийн “Ажлын зураг, төсөв” боловсруулах газрын судалгааг газар дээр нь орон нутгийн болон, захиалагч байгууллагын төлөөлөлтэй хамтран хийх, байрзүйн дэвсгэр зураглал хийлгэх /байгаа бол тодотгох/, инженер геологийн дүгнэлт гаргуулах, инженерийн дэд бүтэцтэй хэрхэн холбогдох талаар урьдчилсан судалгааг хангагч байгууллагатай хамтран хийж засал зөвлөмж гаргах.
3. “Архитектур төлөвлөлтийн даалгавар” авах
  - “Архитектур төлөвлөлтийн даалгавар”-г Захиалагч, ашиглагч байгууллагатай хамтран Хөвсгөл аймгийн эрх бүхий байгууллагаас авна.
  - “Архитектур төлөвлөлтийн даалгавар”-н дагуу Захиалагч, ашиглагч байгууллагатай хамтран Зураг төсөл боловсруулах даалгаврын дагуу Загвар зураг төсөл боловсруулах санал солилцох
4. Загвар зураг төсөл боловсруулах:
  - Захиалагч, ашиглагч байгууллагатай зөвшилцсөний дагуу, Зураг төсөл боловсруулах даалгаврын хүрээнд барилга байгууламжийн байгуулалт, отглол, нүүр тал болон харагдах байдал, ерөнхий төлөвлөгөөг “Архитектур төлөвлөлтийн даалгавар”-г үндэслэн 1-2 хувилбараар боловсруулж Захиалагч, ашиглагч байгууллагаар батлуулах
  - Захиалагч, ашиглагч байгууллагын баталсан Загвар зураг төслийг Хөвсгөл аймгийн холбогдох байгууллагаар батлуулна. Үүнд:
    1. Захиалагч /ashiaglagch/
    2. Хөвсгөл аймгийн ХОХБТХ, ГХБХБГ, Ерөнхий архитектор, МХГ-аар батлуулж дүгнэлт гаргуулна, ОБГ-аар батлуулж дүгнэлт гаргуулна.
5. Техникийн нөхцөл авах:
  - Батлагдсан Загвар зураглалыг үндэслэн хангагч байгууллагаас доорх техникийн нөхцөлүүдийг Захиалагч байгууллагатай хамтран авна.
    1. Дулааны техникийн нөхцөл
    2. Цэвэр бохир усны техникийн нөхцөл
    3. Цахилгааны техникийн нөхцөл
    4. Холбооны техникийн нөхцөл
  - Олгогдсон техникийн нөхцөлийн дагуу Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын хангагч байгууллагуудаас гадна шугам сүлжээний холбогдох цэгийн дэлгэрэнгүй тодруулга, мэдээлэл авч, газар дээр нь судалгаа хийнэ.

Захиалагчийг төлөөлж.....

Гүйцэтгэгчийг төлөөлж.....

6. Ажлын зураг боловсруулалт

- Батлагдсан загвар зураг төсөл болон Зураг төсөл боловсруулах даалгавар, Архитектур төлөвлөлтийн даалгаврын дагуу Ерөнхий төлөвлөгөө, Барилга архитектурын зураг төсөл боловсруулж, хорших зураглалын инженерүүдэд даалгавар өгнө. Үүнд:
  1. Барилга бүтээц
  2. Халаалт агаар сэлгэлт
  3. Цэвэр бохир ус
  4. Хүчтэй төхөөрөмж, дотор гэрэлтүүлэг
  5. Холбоо дохиолол
  6. Автоматжуулалтанд даалгавар өгч ажлын зураг төсөл боловсруулна
- ХАС, ЦБУ, ХТ-ДГ, ХД-н инженерүүдийн боловсруулсан мэдээлэл болон холбогдох техникийн нөхцөлүүдийг үндэслэн Ерөнхий төлөвлөгөөний зураг төсөлд тодотгол хийж, гадна шугам сүлжээний зураглалын инженерүүдэд даалгавар өгнө. Үүнд:
  1. Гадна дулаан
  2. Гадна цэвэр бохир ус
  3. Гадна цахилгаан
  4. Гадна холбоонд даалгавар өгч, гадна шугам сүлжээний трасс гарган Захиалагч байгууллага болон холбогдох хангагч байгууллагуудтай зөвшилцөн ажлын зураг төсөл боловсруулна

7. Ажлын зураг төслийн хяналт:

- Ажлын зураг боловсруулах шатанд Захиалагч болон Гүйцэтгэгч хамтран 2-3 удаа зураг төсөлд хяналт хийж Захиалагч байгууллагад гүйцэтгэлийн тайлан явуулна
- Дууссан ажлын зураг төслийг Захиалагч байгууллагаар бүрэн хянуулна

8. Ажлын зураг төслийн баталгаажуулалт:

- Ажлын зураг төслийг орон нутгийн холбогдох байгууллагаар батлуулж, дүгнэлт гаргуулна. Үүнд: Хөвсгөл аймгийн ХОХБТХ, ГХБХБГ, Ерөнхий архитектор, МХГ-аар батлуулж дүгнэлт гаргуулна, ОБГ-аар батлуулж дүгнэлт гаргуулна.
- Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын хангагч байгууллагаар гадна инженерийн шугам сүлжээний ажлын зургийг баталгаажуулна.
- БХТ-н Зураг төслийн магадлалын хэлтсээр ажлын зураг төслийг батлуулж, баталгаажсан зураг төсөлд төсөв хийж Магадлалын ерөнхий дүгнэлт гаргуулах

9. Ажлын зураг, төсөв хүлээнцэх:


- Магадлалын ерөнхий дүгнэлт авсан Ажлын зураг төсвийг Захиалагч байгууллагад акт үйлдэн хүлээнлгэн өгнө
- "Ажлын зураг, төсөв боловсруулах гэрээ"-г Захиалагч болон Гүйцэтгэгч тал хамтран дүгнэнэ

Захиалагчийг төлөөлж.....

Гүйцэтгэгчийг төлөөлж.....

### 3.7. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ АЖИЛЛАХ ХУВААРЬ

| Дотоодын зөвлөх |                |                                       | Ажлын 5 хоногоор |   |   |   |   |   |   |            |
|-----------------|----------------|---------------------------------------|------------------|---|---|---|---|---|---|------------|
| Д/д             | Нэр            | Албан тушаал                          | Тайлан гарах     | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | Нийт хоног |
| 1               | Д.Минжбадгар   | Захирал, ББ мэргэшсэн инженер         |                  |   |   |   |   |   |   |            |
| 2               | Т.Тамир        | Төслийн удирдагч, Зөвлөх архитектор   |                  |   |   |   |   |   |   |            |
| 3               | Э.Содмандах    | Архитектор, ГИП                       |                  |   |   |   |   |   |   |            |
| 4               | Д.Дагийсурэн   | Архитектор                            |                  |   |   |   |   |   |   |            |
| 5               | Б.Сугармаа     | ББ инженер                            |                  |   |   |   |   |   |   |            |
| 6               | Б.Энхнаран     | ХАС Мэргэшсэн инженер                 |                  |   |   |   |   |   |   |            |
| 7               | Б.Баасанжаргал | ХАС инженер                           |                  |   |   |   |   |   |   |            |
| 8               | А.Энхтуяа      | УХАТ Зөвлөх инженер                   |                  |   |   |   |   |   |   |            |
| 9               | Ж.Нарангэрэл   | УХАТ инженер                          |                  |   |   |   |   |   |   |            |
| 10              | Ж.Амарсанаа    | Цахилгааны Зөвлөх инженер /гэрээт/    |                  |   |   |   |   |   |   |            |
| 11              | Г.Золбоо       | Цахилгааны Мэргэшсэн инженер /гэрээт/ |                  |   |   |   |   |   |   |            |
| 12              | Ж.Наранцэцэг   | ХД, Зөвлөх инженер                    |                  |   |   |   |   |   |   |            |
| 13              | Д.Мөнхсайхан   | ХД, инженер                           |                  |   |   |   |   |   |   |            |
| 14              | Ө.Батчимэг     | Мэргэшсэн төсөвчин                    |                  |   |   |   |   |   |   |            |
| 15              | Д.Зоригтбаатар | Менежер, Техникич                     |                  |   |   |   |   |   |   |            |
| 16              | Ч.Ундрах       | Техникич                              |                  |   |   |   |   |   |   |            |



Захиалагчийг төлөөлж.....



Гүйцэтгэгчийг төлөөлж.....

## II. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### 1. ЕРӨНХИЙ ЗААЛТ

#### 1.1 Нэр томъёоны тайлбар

- 1.1 Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
- (а) “Гэрээнд хэрэглэх хууль” гэж Гэрээний тусгай нөхцөл ГТН-д заасан Монгол улсын хүчин төгөлдөр хууль болон бусад эрх зүйн актыг хэлнэ.
  - (б) “Зөвлөх” гэж захиалагчтай байгуулсан энэхүү гэрээнд заасан үйлчилгээг үзүүлж байгаа аливаа хувийн болон төрийн хуулийн этгээдийг хэлнэ.
  - (в) “Гэрээ” гэж талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт болон түүний 1 дүгээр заалтад дурдсан бусад баримт бичгүүд болох Гэрээний ерөнхий нөхцөл, Гэрээний тусгай нөхцөл болон хавсралт баримт бичгүүдийг хэлнэ.
  - (г) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
  - (е) “Гэрээ хүчин төгөлдөр болох огноо” гэж ГЕН-ийн 2.1-д заасан гэрээ хүчин төгөлдөр болох огноог хэлнэ.
  - (д) “Гэрээний үнэ” гэж ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу Үйлчилгээний гүйцэтгэлийн төлөө Зөвлөхөд төлөх төлбөрийн хэмжээг хэлнэ.
  - (е) “ГЕН” гэж Гэрээний ерөнхий нөхцлийг хэлнэ.
  - (ё) “Гишүүн” гэж түншлэл/консорциум/холбоог бүрдүүлж байгаа аль нэгэн хуулийн этгээдийг “Гишүүд” гэж эдгээр хуулийн этгээдийг хамтад нь хэлнэ.
  - (ж) “Гэрээний тал гэж” Захиалагч эсхүл Зөвлөхийн аль нэгийг, харин “Талууд” гэж хоёуланг нь хэлнэ.
  - (з) “Нөхөн төлөх зардал” гэж зөвлөхийн ажлын хөлснөөс бусад үйл ажилгаатай холбоотой бүх зардлуудыг хэлнэ.
  - (л) “ГТН” гэж гэрээний ерөнхий нөхцөлийг тодотгож байгаа Гэрээний тусгай нөхцлийг хэлнэ.
  - (м) “Үйлчилгээ” гэж Хавсралт №1-т тодорхойлсон, энэхүү гэрээнд заасны дагуу Зөвлөхийн хийж гүйцэтгэвэл зохих ажлыг хэлнэ.
  - (о) “Туслан гүйцэтгэгч” гэж үйлчилгээний аль нэгэн хэсгийг туслан гүйцэтгэхээр Зөвлөхтэй гэрээ байгуулсан хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ.
  - (ө) “Ажиллах хүчин ” гэж Үйлчилгээ буюу түүний аль нэгэн хэсгийг гүйцэтгүүлэхээр Зөвлөхийн эсхүл туслан гүйцэтгэгчийн хөлсөлсөн хувь хүнийг хэлнэ.

#### 1.2 Гэрээнд

Энэхүү гэрээ, түүний агуулга болон тайлбар, мөн талуудын

Захиалагчийг төлөөлж.....

Гүйцэтгэгчийг төлөөлж.....

|            |   |  |
|------------|---|--|
|            | <b>хэрэглэгдэх хууль</b>                      | харилцааг ГТН-д заасан хууль тогтоомжоор зохицуулна.   |
| <b>1.3</b> | <b>Гэрээнд ашиглах хэл</b>                    | Энэхүү гэрээ нь ГТН-д заасан улсын хэл дээр боловсруулагдсан бөгөөд гэрээний агуулга, тайлбартай холбоотой бүх асуудалд уг хэлийг ашиглана. Талууд хоорондын харилцах бичиг баримт нь энэ хэл дээр байна.  |
| <b>1.4</b> | <b>Мэдэгдэл</b>                               | Энэхүү гэрээний дагуу олгогдсон эсхүл шаардагдах аливаа мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл зэргийг бичгээр үйлдсэн байх ёстой. Эдгээр мэдэгдэл, хүсэлт буюу зөвшөөрөл нь харилцаж байгаа талын итгэмжлэгдсэн төлөөлөгчид биечлэн хүргэгдсэн эсхүл ГТН-д заасан хаягаар илгээсэн тохиолдолд олгогдсон гэж тооцогдох ёстой.   |
| <b>1.5</b> | <b>Байршил</b>                                | Үйлчилгээг, гэрээний хавсралт №1-т заасан нутаг дэвсгэрт, хэрэв тодорхой төсөл арга хэмжээний байрлалыг заагаагүй тохиолдолд захиалагчийн харьяа улс эсхүл түүний тодорхойлж өгсөн нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх ёстой.   |
| <b>1.6</b> | <b>Төлөөлөх эрх бүхий гишүүний эрх хэмжээ</b> | Зөвлөх нь түншлэл/консорциум/ хоёр буюу түүнээс дээш хуулийн этгээдийн холбооноос бүрдэж байгаа тохиолдолд, эдгээр гишүүд гэрээний дагуу захиалагчтай үүсэх харилцаанд бүх гишүүний нэрийн өмнөөс оролцох, эрх хэрэгжүүлэх болон үүрэг хүлээх, зааварчилгаа болон төлбөр хүлээн авахад тэднийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүнийг томилно.   |
| <b>1.7</b> | <b>Итгэмжлэгдсэн төлөөлөгч</b>                | Гэрээний дагуу захиалагч эсхүл зөвлөхийн гүйцэтгэвэл зохих аливаа үйл ажиллагаа болон баримт бичгийг ГТН-д заасан албан тушаалтан хариуцан хийнэ.  |
| <b>1.8</b> | <b>Татвар, хураамж</b>                        | Зөвлөх, туслан гүйцэтгэгч болон тэдгээрийн ажиллах хүчин нь ГТН-д заасан гэрээнд хэрэглэх хуулийн дагуу төлбөл зохих татвар, хураамж болон төлбөрийг төлөх ёстой.  |
| <b>1.9</b> | <b>Авиалгал болон залилан мэхлэх үйлдэл</b>   | Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч, гэрээ хэрэгжүүлэгч зөвлөх бүр худалдан авах ажиллагаанд оролцох, худалдан авах гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх ёстой.<br>Худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон зөвлөх нь Авиалгын эсрэг хууль, Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авиалгал, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдсон талаар бодитой мэдээлэл байгаа бол холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад зохих ёсоор мэдэгдэнэ. |

## **2. ГЭРЭЭ ЭХЛЭХ, ДУУСГАВАР БОЛОХ, ТҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ БОЛОН ЦУЦЛАХ**

|            |                                   |  |
|------------|-----------------------------------|--|
| <b>2.1</b> | <b>Гэрээ хүчин төгөлдөр болох</b> | Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан, эсхүл ГТН-д заасан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Гэрээг хүчин төгөлдөр болох өдрийг гэрээ хүчин төгөлдөр болох огноо гэж хэлнэ. |
| <b>2.2</b> | <b>Үйлчилгээг эхлэх</b>           | Зөвлөх нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хоногт багтаан үйлчилгээг эхлэх ёстой.   |
| <b>2.3</b> | <b>Гэрээний хугацаа дуусгавар</b> | ГЕН-ийн 2.6-д заасны дагуу цуцлагдаагүй бол гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш ГТН-д заасан хугацааны дараагаар  |

Захиалагчийг төлөөлж.....

Гүйцэтгэгчийг төлөөлж.....

|  |   |
|--|---|
| <b>боловх</b>                                    | энэхүү гэрээний хугацаа дуусгавар болно.  |
| <b>2.4 Гэрээний өөрчлөлт буюу засвар</b>         | Гагцхүү бичгээр үйлдэн талууд гарын үсэг зурж баталгаажуулсан тохиолдолд гэрээний нөхцөл, болзол болон үйлчилгээний цар хүрээг засварлах, эсхүл өөрчилж болно.  |
| <b>2.5 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл</b> | <p>2.5.1 Дайн, иргэний бослого, түймэр, үер, халдварт өвчин, газар хөдлөлт, хорио цээр, тээврийн хориг болон бусад гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдал үүссэнээс захиалагч, эсхүл нийлүүлэгч, эсхүл туслан гүйцэтгэгчийн гэрээний үүргийн гүйцэтгэл хугацаа хоцорсон бол талууд тохиролцон гүйцэтгэх хугацааг сунгана.</p> <p>2.5.2 Гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдал үүссэн тохиолдолд нийлүүлэгч нь энэ нөхцөл байдал болон үүссэн шалтгааны талаар захиалагчид нэн даруй бичгээр мэдэгдэнэ. Захиалагч бичгээр өөрөөр зааварлаагүй бол Зөвлөх гэрээний үүргээ боломжтой хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж, гэнэтийн болон давагдашгүй хүчиний нөхцөл байдлаас үл шалтгаалан гэрээг хэрэгжүүлэх боломжит арга замыг хайна.</p> |

## 2.6 Гэрээ цуцлах

- 2.6.1 Захиалагч гэрээг цуцлах** Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй.
- (а) Зөвлөх гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараагаар 30 хоног, эсхүл захиалагчийн бичгээр зөвшөөрөн сунгасан хугацаанд багтаан мэдэгдэлд дурдсан зөрчлийг арилган үүргийн гүйцэтгэлийг хангаагүй:
  - (б) Зөвлөх (эсхүл түншлэлийн аль нэг гишүүн) төлбөрийн чадваргүй болсон, эсхүл дампуурсан, эсхүл дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, эсхүл сайн дураараа буюу албадан журмын дагуу татан буугдаж байгаа:
  - (в) Зөвлөх нь тендерт оролцох буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгал, запилан мэхлэх үйлдэлд холбогдсон байж болох хангалттай үндэслэл захиалагчид байгаа:
  - (г) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон:
  - (д) Захиалагч өөрийн санаачлагаар дээр зааснаас бусад үндэслэлээр гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн бол:
  - (е) Зөвлөх ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрийн ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй:
- 2.6.2 Зөвлөхийн санаачлагаар** Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд

Захиалагчийг төлөөлж.....

Гүйцэтгэгчийг төлөөлж.....

- гэрээг цуцлах** зөвлөх өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй
- (а) захиалагч нь ГЕН-ийн 7 дугаар зүйлд заасны дагуу ямар нэгэн маргаан үүссээгүй үед гэрээний дагуу төлбөл зохих аливаа төлбөрийг зөвлөхийн бичгээр гаргасан төлбөрийн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 45 хоногийн дотор төлөөгүй
  - (б) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 60-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон:
  - (в) Захиалагч ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрийн ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй:
  - (г) Захиалагч гэрээний дагуу хүлээсэн үргээ ноцтой зөрчсөн бөгөөд энэхүү зөрчлийн талаарх мэдэгдлийг хүлээн авснаас хойш 45 хоногийн хугацаанд ( эсхүл зөвлөхийн бичгээр зөвшөөрөн сунгасан хоногт багтаан) тухайн зөрчлийг арилгаагүй:

#### **2.6.2 Гэрээг цуцласан үед хийх төлбөр**

ГЕН-ийн 2.9.1 болон 2.9.2 зүйлд заасны дагуу гэрээг цуцласан үед захиалагч дараах төлбөрийг зөвлөхөд төлөх ёстай:

- (а) Гэрээг цуцлах өдрөөс өмнө зохих ёсоор гүйцэтгэсэн бөгөөд ГЕН-ийн 6 дугаар зүйлд заасны дагуу төлбөл зохих үйлчилгээний хөлс:
- (б) ГЕН-ийн 2.6.1-ийн (а)-гаас (в) хүртлэх, мөн (е) заалтын дагуу гэрээг цуцалснаас бусад тохиолдолд зөвлөхийн ажилтнууд, тэдний хууль ёсны хамтран амьдрагч нарыг буцаах замын зардал зэрэг гэрээг цуцласны улмаас үүсэх аливаа бодит зардлын нөхөн олговор:

### **3. ЗӨВЛӨХИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**

#### **3.1 Ерөнхий зүйл**

##### **3.1.1 Гүйцэтгэлийн чанар**

Зөвлөх нь гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх ёстай бөгөөд тоног төхөөрөмж, машин механизм болон материалын хувьд аюулгүй, үр дүнтэй болон зүй зохист арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг ханган ажиллах ёстай.

Зөвлөх нь гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт захиалагчийн зөвлөхийн хувиар хандан ажиллах бөгөөд туслан гүйцэтгэгч буюу гуравдагч этгээдтэй хийх аливаа харилцаанд захиалагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ёстай.

##### **3.2 Ашиг сонирхлын зөрчил**

Зөвлөх нь ирээдүйд хийх ажилтай холбоотой ямар нэгэн зүйлийг үл харгалзан захиалагчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих ёстай бөгөөд өөр төсөл арга хэмжээ буюу өөрийн байгууллагын эрх ашигтай, сонирхолын зөрчилд орохоос зайлсхийх ёстай.

Захиалагчийг төлөөлж.....

Гүйцэтгэгчийг төлөөлж.....

|   |  |
|---|--|
| <b>3.3 Нууцлал</b>  | Зөвлөх, түүний ажилтнууд нь захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр гэрээний хэрэгжилтийн явцад олж авсан аливаа нууц мэдээллийг ямар нэгэн хувь хүн, байгууллагад дамжуулах эрхгүй бөгөөд үйлчилгээний үр дүнд боловсруулсан зөвлөмжийг нийтэд нээлттэй болгох эрхгүй  |
| <b>3.4 Зөвлөхийн хариуцах даатгал</b>                                     | Зөвлөх нь захиалагчийн зөвшөөрсөн нөхцөл, болзолын дагуу болон ГТН-д тусгайлан заасан эрсдэлд хамаарах даатгалыг өөрийн зардлаар хариуцан хийлгэх бөгөөд даатгалын гэрээ, гэрчилгээг захиалагчид ирүүлнэ.  |
| <b>3.5 Захиалагчаас урьдчилан зөвшөөрөл авбал зохих үйл ажиллагаа</b>     | Зөвлөх нь дор дурдсан үйл ажиллагааг явуулахаас өмнө захиалагчийн зөвшөөрлийг бичгээр авсан байх ёстой. Үүнд:  |
|   | (а) Үйлчилгээний аль нэг хэсгийн гүйцэтгэлийг туслан гүйцэтгэх гэрээгээр хийлгэх,  |
|   | (б) Хавсралт №1-т заасан ажилтны жагсаалтанд ямар нэг өөрчлөлт, нэмэлт оруулах.  |
|   | (в) ГТН-д тусгайлан заасан бусад үйл ажиллагаа   |
| <b>3.6 Тайлاغнах хуваарь</b>  | Зөвлөх нь Хавсралт №2 -т заасан тайлан болон баримт бичгийг тухайн хавсралтад заасан маягтын дагуу тогтоосон хугацааны дотор хүргүүлэх ёстой.  |
| <b>3.7 Зөвлөхийн боловсруулсан баримт бичиг захиалагчийн өмч болох нь</b> | Энэхүү гэрээний дагуу захиалагчид зориулж зөвлөхийн боловсруулсан аливаа судалгаа, тайлан, зураг, график, программ хангамж болон бусад материал, эд зүйл нь захиалагчийн өмч болж үлдэх бөгөөд гэрээ дуусгавар болох, гэрээ цуцлахаас өмнө эдгээр материалыг дэлгэрэнгүй жагсаалтын хамтаар захиалагчид хүргүүлнэ. Зөвлөх нь эдгээр бичиг баримт болон программ хангамжийн хувийг авч болно. |
| <b>3.8 Нягтлан бодох бүртгэл, Хяналт шалгалт болон Аудит</b>              | Зөвлөх нь гэрээний гүйцэтгэлд хамаарах нягтлан бодох данс, бүртгэлийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зарчмын дагуу хөтлөн явуулах бөгөөд захиалагч түүний томилсон төлөөлөгч эсхүл аудитор эдгээр данс, бүртгэлд хөндлөнгийн шалгалт хийх эрхтэй.   |

#### 4. ЗӨВЛӨХИЙН АЖИЛТNUУД

|   |   |
|---|---|
| <b>4.1 Ажиллах хүчиний тодорхойлолт</b> | Зөвлөхийн санал болгож буй гол мэргэжилтэн бүрийн албан тушаал, ажлын байрны тодорхойлолт, мэргэжлийн түвшин болон үйлчилгээг гүйцэтгэхэд оролцох хугацаа зэргийн талаарх мэдээллийг Хавсралт №3-т тусгана. Захиалагчтай урьдчилан тохиролцсон гол мэргэжилтний мэдээллийг мөн хавсралтанд багтаана.  |
| <b>4.2 Ажилтныг халах буюу солих</b>    | (а) Захиалагч зөвшөөрөөгүй бол ажиллах хүчиний бүрэлдэхүүнд ямар нэгэн өөрчлөлт хийх ёсгүй. Зөвлөхийн эрх хэмжээнээс үл хамаарах, тухайлбал, тэтгэвэрт гарах, нас барах, эрүүл мэндийн хувьд чадваргүй болох, бусад шалтгааны улмаас ажилтныг солих зайлшгүй шаардлага гарвал түүнтэй тэнцүү буюу илүү чадвартай хүнээр солих асуудлыг цаг алдалгүй |

Захиалагчийг төлөөлж.....

Гүйцэтгэгчийг төлөөлж.....

тавина.

- (б) Аль нэгэн ажилтан үүргээ ноцтой зөрчсөн буюу гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үүргийн гүйцэтгэл хангалтгүй байгаа талаар хангалттай үндэслэл захиалагчид байгаа тохиолдолд захиалагчаас бичгээр гаргасан үндэслэл бүхий шаардлагын дагуу түүний хүлээн зөвшөөрхүйц чадвар болон туршлага бүхий ажилтнаар солих ёстай.
- (в) Ажилтныг халах, эсхүл солихтой холбоотой үүсч болох ямар нэгэн нэмэлт зардлыг зөвлөх нэхэмжлэх эрхгүй болно.

### 5. ЗАХИАЛАГЧИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

|  |   |
|--|---|
| <b>5.1 Дэмжлэг үзүүлэх болон зөвшөөрөл олгох</b>                                     | Захиалагч нь ГТН-д заасан зөвлөхөд үзүүлэх дэмжлэг, туслалцаа болон холбогдох зөвшөөрлийг засгийн газрын зүгээс олгуулахын тулд бүх талын хүчин чармайлт гаргана.   |
| <b>5.2 Гэрээнд хэрэглэх хуулинд татвар талаар орсон өөрчлөлт</b>                     | Хэрэв, гэрээ байгуулагдсанаас хойш гэрээнд хэрэглэх хуулинд татвар, хураамжийн талаар орсон өөрчлөлтийн улмаас үйлчилгээний гүйцэтгэлийн дагуу Зөвлөхийн хүлээн авах төлбөр нэмэгдэх буюу хасагдахаар байгаа бол, талууд тохиролцон гэрээний дагуу Зөвлөхөд төлөх цалин болон нөхөн төлөгдөх зардлын хэмжээг өөрчлөх бөгөөд энэхүү холбогдох үнийн тохируулга нь ГЕН-ийн 6.2 (а), (б), -д заасан төлбөрийн хэмжээнд нийцсэн байх ёстай. |
| <b>5.3 Захиа лагчийн зүгээс үзүүлэх, үйлчилгээ, тоног төхөөрөмж болон эд хөрөнгө</b> | Захиалагч нь үйлчилгээний зорилгоор ашиглуулахаар Хавсралт 3.3-д заасан үйлчилгээ, тоног төхөөрөмж болон эд хөрөнгийг тогтоосон хугацаанд үнэ төлбөргүйгээр Зөвлөхөд гарган өгөх ёстай.   |

### 6. ЗӨВЛӨХӨД ТӨЛӨХ ТӨЛБӨР

|                                       |  |
|---------------------------------------|--|
| <b>6.1 Нийт төлбөр</b>                | Зөвлөхөд төлөх нийт төлбөрийн хэмжээ нь гэрээний хавсралт №1-т тодорхойлсон үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах бүх зардлыг тооцсон тогтмол нийт үнийг багтаасан гэрээний үнээс хэтрэх ёсгүй. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу өөрчлөснөөс бусад тохиолдолд ГЕН-ийн 6.2-т тодорхойлсон үнийн хэмжээг гагцхүү ГЕН-ийн 2.4-т зааснаар талууд нэмэлт төлбөр хийхийг зөвшөөрсөн тохиолдолд нэмэгдүүлж болно. |
| <b>6.2 Гэрээний үнэ</b>               | (а) Гадаад мөнгөн тэмдэгтээр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.<br>(б) Төгрөгөөр хийх төлбөрийн хэмжээг ГТН-д тодорхойлно.  |
| <b>6.3 Нэмэлт үйлчилгээний төлбөр</b> | ГЕН-ийн 2.4-т заасны дагуу төлөхөөр зөвшөөрч болох нэмэлт үйлчилгээний цалингийн хэмжээг тодорхойлохын тулд нийт үнийн задаргааг Хавсралт №4 болон №5-д оруулна.   |
| <b>6.4 Төлбөр хийх</b>                | Төлбөрийг ГТН-д заасан төлбөр хийх хуваарийн дагуу, тэнд заасан  |

Захиалагчийг төлөөлж.....

Гүйцэтгэгчийг төлөөлж.....

**нөхцөл.  
хуваарь**

зөвлөхийн дансанд хийнэ. ГТН-д өөрөөр заагаагүй бол, түүнд тогтоосон хугацаанд хүчинтэй байхаар тооцож, зөвлөхийн ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн баталгааны дүнтэй тэнцэх хэмжээгээр эхний төлбөрийг хийнэ. Энэхүү баталгааг Хавсралт №7-д заасан маят, эсхүл захиалагчийн бичгээр гаргасан зөвшөөрсөн өөр маягтаар гарган ирүүлнэ.

ГТН-д заасан нөхцөл болзолыг хангасны дараа, зөвлөхөд төлбөл зохих төлбөрийн хэмжээг тодорхойлсон нэхэмжлэлийг захиалагчид ирүүлснээр бусад төлбөр хийгдэх ёстай.

**6.5 Хугацаа  
хоцорсон  
төлбөрийн  
хүү**

Захиалагч нь ГТН-ийн 6.4-д тогтоосон төлбөр хийх хугацааг арван таван хоногоос (15) дээш хоногоор хэтрүүлсэн бол хугацаа хоцорсон хоног тутам ГТН-д тогтоосон хэмжээгээр зөвлөхөд хүү төлөх ёстай.

**7.1 Шударга  
байдал**

Талууд энэхүү гэрээний дагуу үйл ажиллагаа явуулахдаа бие биенийхээ эрхийг хүндэтгэн, шударга байдлаар хандах ба гэрээний зорилгыг хэрэгжилтийг хангахын тулд бүхий л зохистой арга хэмжээг авна.

**8. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ**

**8.1 Маргааныг  
эв зүйгээр  
шийдвэрлэх**

Маргаанаас зайлсхийх, эсхүл түүнийг цаг алдалгүй шийдвэрлэх нь гэрээний гүйцэтгэлийг сайтар хангах болон төсөл арга хэмжээний амжилтанд ихээхэн чухал гэдгийг талууд хүлээн зөвшөөрнө. Гэрээтэй холбоотой аливаа маргааныг талууд харилцан тохиролцож, эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

**8.2 Маргааныг  
шийдвэрлэх**

Талууд гэрээний холбоотой аливаа маргааныг эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд аль нэг тал нь ГТН-д заасан маргааныг шийдвэрлэх арга хэрэгслийг сонгох эрхтэй.

Захиалагчийг төлөөлж.....

Гүйцэтгэгчийг төлөөлж.....

ХӨАОНӨГ/202201157-100  
дугаар гэрээний хавсралт №5

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

|                        |   |
|------------------------|---|
| ГЕН-ийн зүйлийн дугаар | Гэрээний ерөнхий нөхцлийн холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах буюу өөрчлөнө.   |
| {1.1(a)}               | Гэрээнд хэрэглэх хууль нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Иргэний хууль,   |
| 1.3                    | Гэрээний баримт бичгүүд нь Монгол хэл дээр байна.   |
| 1.4                    | Захиалагчийн хаяг: Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр.<br>Захиалагч: Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга<br>Харилцах хүн: Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга П.Ариунбат   |
| 1.8                    | Татвар: Зөвлөх нь Монгол Улсын хууль тогтоомжид заасан татвар хураамжийг төлнө.   |
| {2.1}                  | Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр: 2022-10-05   |
| 2.2                    | Тогтоосон хугацаа: Зөвлөх нь гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 5 хоногт багтаан үйлчилгээг эхлэх ёстой.  |
| 2.3                    | Тогтоосон хугацаа: Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш 60 хоногийн дараагаар энэхүү гэрээний хугацаа дуусгавар болно.  |
| 2.6                    | Энэхүү зүйлд заасан дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд захиалагч өөрийн санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй.<br><br>а) Зөвлөх гэрээний дагуу хүлээсэн үүргээ зөрчсөн талаарх мэдэгдлийг хүлээн авсны дараагаар 30 хоног, эсхүл захиалагчийн бичгээр зөвшөөрөн сунгасан хугацаанд багтаан мэдэгдэл дурдсан зөрчлийг арилган үүргийн гүйцэтгэлийг хангаагүй;<br><br>(б) Зөвлөх (эсхүл түншлэлийн аль нэг гишүүн) төлбөрийн чадваргүй болсон, эсхүл дампуурсан, эсхүл дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, эсхүл сайн дураараа буюу албадан журмын дагуу татан буугдаж байгаа:<br><br>(в) Зөвлөх нь тендерт оролцох буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгал, залилан мэхлэх үйлдэлд холбогдсон байж болох хангалттай үндэслэл захиалагчид байгаа:<br><br>(г) Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэний улмаас Зөвлөх нь 20-аас дээш хоногийн хугацаанд үйлчилгээний голлох хэсгийг гүйцэтгэх боломжгүй болсон;<br><br>(д) Зөвлөх нь захиалагчийн баталсан зураг, төслийн даалгавар, техникийн нөхцөлд заасан өгөгдөл, шаардлагад нийцэхгүй зураг төсөл боловсруулсан, ажиллах хүчиний хуваарыт заасан хүний нөөцийг |

Захиалагчийг төлөөлж.....

Гүйцэтгэгчийг төлөөлж.....


|           |  |
|-----------|--|
|           | <p>ажиллуулаагүй, гэрээний аль нэг үүргээ хангалтгүй биелүүлсэн зэрэг зөрчлүүдийн аль нэгийг гаргасан тохиолдолд захиалагч өөрийн санаачлага бусад үндэслэлээр гэрээг цуцлахаар шийдвэрлэсэн бол:</p> <p>(е) Зөвлөх ГЕН-ийн 7 зүйл заасны дагуу арбитрийн ажиллагааны үр дүнд гаргасан эцсийн шийдвэрийг биелүүлээгүй:</p>   |
| 3.4       | <p>Даатгалд зайлшгүй хамруулах зүйл, даатгалын дүнгийн доод хэмжээ нь:</p> <p>(а) Машин механизм, тоног төхөөрөмжийн алдагдал, эсхүл гэмтлийн даатгалд зөвлөхийн доод хэмжээ нь [мөнгөн дүн] байна.</p> <p>(б) Гуравдагч этгээдийн хариуцлагын даатгалд зөвлөхийн төлөх хэмжээ нь [мөнгөн дүн] байна.</p> <p>(в) Мэргэжлийн хариуцлагын даатгалд зөвлөхийн төлөх хэмжээ нь [мөнгөн дүн] байна.</p> <p>(г) Гэнэтийн ослын, амь нас, эрүүл мэндийн хувьд гэрээнд хэрэглэх хуулийн дагуу ажил олгогчийн хүлээх хариуцлагын даатгалд зөвлөхийн төлөх хэмжээ нь [мөнгөн дүн] байна.</p> <p>Тэмдэглэл: Энд хэрэглэх шаардлагтай гэж үзсэн даатгалын заалтыг нэмэх эсхүл хэрэглэхгүй заалтыг хасна.</p>                           |
| {3.5 (в)} | <p>Бусад үйл ажиллагаа: Зөвлөх нь өөрийн боловсруулсан тайлан, дүгнэлтийг дараах байгууллага, албан тушаалтуудад хандан хянуулж, баталгаажуулсан байна. Үүнд:</p> <p>-Зөвлөх нь Ханх сумын “Соёлын төвийн” барилга (250 хүний хүчин чадалтай) барилгын ажлын зураг төсөл боловсруулах” ажлын тайланг баталгаажуулсан дүгнэлтийг ирүүлсэн байна.</p> <p>-Зөвлөх нь баталгаажсан Ханх сумын “Соёлын төвийн” барилга (250 хүний хүчин чадалтай) барилгын ажлын зураг төсөл боловсруулсан зураг, төсөв 1 эх хувь, 2 хуулбар хувийг тус тус захиалагчийн томилсон ажлын хэсэгт хүлээлгэн өгч, захиалагчтай байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээг дүгнүүлсэн байна.</p>  |
| 6.2(б)    | <p>Төгрөгөөр хийх төлбөрийн дээд хэмжээ: <b>33,105,079 (Гучин гурван сая нэг зуун таван мянга далан есөн ) төгрөг</b></p>  |
| 6.4       | <p>Төлбөр хийх данснууд:</p> <p>Төгрөгийн хувьд: <b>Зөвлөхийн дансны дугаар: Худалдаа хөгжлийн банк 2611015498</b></p>   |
| 6.5       | <p>Хүүгийн хувь хэмжээ: Зөвлөх Ханх сумын “Соёлын төвийн” барилга (250 хүний хүчин чадалтай) барилгын ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээг дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хойш дуусгасан тохиолдолд хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг<sup>7</sup> захиалагчид төлөх ба алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй. Энэхүү алданги нь үе шатны хуваарьт заасан ажил гүйцэтгэх хугацаанд нэгэн адил хамаарна. Зөвлөхөд олгох санхүүжилтийн дүнг алдангийн хэмжээгээр бууруулан олгоно.</p> <p>Зөвлөхөд захиалагчаас олгох санхүүжилтийг хугацаа хоцроосон тохиолдолд санхүүжилт хоцроосон хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх</p> |

Захиалагчийг төлөөлж.....

Гүйцэтгэгчийг төлөөлж.....

|     |   |
|-----|---|
|     | алдангийг захиалагчаас гүйцэтгэгчид төлөх бөгөөд алдангийн нийт хэмжээ гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй. Зөвлөхөд алданги төлөх тохиолдолд гэрээний төлбөрийг алдангийн хэмжээгээр нэмэгдүүлнэ. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүжилт saatnsaas үүсэх алдангийг захиалагч хариуцахгүй. |
| 8.2 | Гэрээтэй холбоотой үүсвэл маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.   |

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:



АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР  
Х.ДАВААСҮРЭН

ЗӨВЛӨХИЙГ ТӨЛӨӨЛЖ:



“ЭМ ЭМ ИНЖЕНЕРИНГ” ЖХК-ИЙН  
АРХИТЕКТОР ..... Э.СОДМАНДАХ

Захиалагчийг төлөөлж.....

Гүйцэтгэгчийг төлөөлж.....